



КЮУШУ МОНГОЛЫН “ТООНО” НАЙРАМДАЛЫН ХОЛБОО

ҮҮСЭХ БОЛСОН ТҮҮХ

Япон улсын Кюүшү аралд амьдарч байсан Монгол залуусын дунд Монголчуудын холбоо байгуулах санаа яригдаж явсаар 2011 оны 3-р сарын 11-ний Фукушимагийн газар хөдлөлтийн үеэр биелэлээ олсон юм.

Учир нь энэ байгалийн гамшиг олон зуун хүний амь насыг авч одсон ба Фукуокад амьдарч байсан Монголчууд маань нэгдсэн нэг зохион байгуулалтанд орох чухал хэрэгцээг мэдэрч холбоогоо байгуулахаар сэтгэл шулуудсан юм. Кюүшүд шинээр ирж буй болон Кюүшүгээс явж буй хүмүүс, тэдний гэр бүлийнхэнийх нь тухай бүртгэлтэй байх, Монголынхоо соёлыг танилцуулах, мэдээллээ цаг алдалгүй хоорондоо солилцох, шинээр ирж буй гэр бүл болон тусламж хэрэгтэй нэгэндээ туслах гэсэн зорилгоор 2011 оны 3-р сарын 20-ний нэгэн бороотой өдөр Кайзука паркад анхныхаа хурлаа хийж холбооны дарга болон удирдах зөвлөлийн гишүүдээ сонгосон юм.

Тэр өдрөө 22,000 япон иен цуглуулан гамшигт нэрвэгдсэн Фукушима мужид илгээж, энэ тухай “Ниши Нихон ” сонинд нийтлэгдэж байсан.

Холбоогоо нэгэн доор цуглардаг, Монгол хүний халуун дулаан сэтгэлийг нэгтгэдэг гэрийн тооноор “ТООНО” хэмээн нэрлэх саналыг Ш. Алтан-Эрдэнэ дэвшүүлж хэлэлцсэний эцэст “ТООНО” хэмээн нэрлэх болсон юм. Холбооны эмблемийн дизайныг А.Самбуу, Саранхүү нар зохион бүтээсэн.

Ийнхүү 2011 оны 4 сараас Фукуока мужид албан ёсны бүртгэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулах нэгэн холбоо мэндэлсэн билээ. Энэ үеэс хойш Наадам, цагаан сар, спортын тэмцээн, шинээр ирсэн оюутан залуустаа яриа хийх, япон улсад төвхөнөхөд нь туслах зэрэг ажлуудыг холбооны үе үеийн гишүүд маань сайн дурын үндсэн дээр хийж ирсэн байна.

ЗОРИЛГО

Холбооны зорилго нь Япон улсын Кюүшү аралд оршин сууж буй монгол иргэддээ туслах, оюутнуудад хандсан сургалт, семинарыг зохион байгуулах, Монголын соёлыг түгээн дэлгэрүүлэх замаар хоёр орны найрамдалт харилцааг улам батжуулах явдал юм.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Кюүшү аралд оршин сууж буй монгол иргэддээ туслах
- Шинээр ирж буй оюутнууд, дэвшин суралцаж буй оюутнуудад уулзалт, семинар хийх
- Монголын соёлыг түгээх
- Дээрхи зорилготой уялдаатай бусад үйл ажиллагаа

ХОЛБООНЫ ТОЙМ

НЭР

Кюүшү Монголын “ТООНО” Найрамдалын Холбоо

НИЙТ ГИШҮҮДИЙН ТОО

Япон улс болон Монгол улсад оршин сууж буй нийт 929 гишүүн (2023 оны 3-р сарын 12-ний байдлаар)

ХОЛБОО БАРИХ

12-1 Kanzeonji 5, Dazaifu city, Fukuoka Prefecture 818-0101

TEL 080-5805-9090

ХОЛБООНЫ ТЭРГҮҮН



Сайн байцгаана уу ?

Намайг Соронзонболд овогтой Сувдаа гэдэг .

Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Олон Улсын Эдийн Засгийн ангийг төгсөөд 2012 онд Фүкүока Олон Улсын Хэлний Коллежид элсэн орохоор японд ирсэн. Тус коллежээ амжилттай дүүргээд Фүкүока Олон Улсын Харилцааны Колежийг Олон Улсын Соёлын ажилтанаар 2015 онд төгссөн .

Японд анх ирээд бусад гадаад оюутнуудын адил мэдэхгүй, чадахгүй зүйлсээр дүүрэн, саад бэрхшээл маш их байсан . Японд бидний өмнө ирсэн ах эгч нарын (сенпай) заавар зөвлөгөөний ачаар өдий хүртэл гэр бүлтэйгээ Фүкүокад амьдарч байна. Япон улсад сэнпай гэдэг ойлголт хүчтэй байдаг ба шинээр ирсэн юу ч мэдэхгүй над шиг оюутнуудад эд нар маань үнэхээр их тусалсан. Японы энэ уламжлал сайхан шүү. Энэ уламжлал үе үеэрээ нэг нэгэндээ туслаж явдаг бичигдээгүй үүрэг хариуцлагад намайг болон миний үеийн бусад оюутнуудыг давхар сургасан юм.

Намайг Японд ирэхээс яг нэг жилийн өмнө буюу 2011 онд ТООНО холбоо маань байгуулагдсан юм билээ. ТООНО холбоо нь миний хувьд японы сэнпай гэдэг уламжлалтай агуулгийн хувьд төстэй мэт санагддаг. Эх нутагаасаа алс хол хэдий ч бид нэг гэр бүлийн ах эгч дүүс мэт байцгаадаг. Хамтдаа уламжлалт баяруудаа тэмдэглэнэ, асуудал тулгарсан нэгэндээ чадлаараа тус дэм болно, зөвлөнө, чиглүүлнэ, мэдээлэл солилцоно, заримдаа бас зэмлүүлнэ.

Хамгийн сэтгэлд хоногшсон нэгэн явдал бол 2016 онд болсон Кумамотогийн газар хөдлөлт юм. Газар хөдлөлт гэдэг ойлголттой анх удаа нүүр тулж байсан Кумамото дахь монгол оюутнуудыг ТООНО холбооны ах эгч нар маш хурдан, өндөр зохион байгуулалттайгаар Фүкүокад авчиран байршуулж байсан явдал. Энэ үйл ажиллагааг хараад бахархах сэтгэлээр цээж маань дүүрч байсан.

Үе үеийн ТООНО холбооны тэргүүн, үйл ажиллагаанд нь оролцож, тусалж дэмжиж байсан сенпай нар маань Японд ирсэн зорилгоо биелүүлэн Монгол руугаа буцах, өөр оронд очиж ажиллаж байгаа ч үргэлж холбоотой байцгаадаг. ТООНО холбоо маань одоогоор 900 гаруй гишүүдтэй болон өргөжин тэлсэн ба үйл ажиллагааны цар хүрээ маань зөвхөн Кюүшүд амьдарч буй залуус гэлтгүй Япон Монгол хоёр орны олон салбарт хүрээгээ тэлэх цаг нь болсон гэж бодож байна. Иймд ТООНО холбооны одоо болон үе үеийн гишүүдийгээ хамтдаа олон сайхан үйл ажиллагааны санаачлагч, чиглүүлэгч, хамтрагч болохыг хүсч байна.

БИД ЭВТЭЙ БАЙХДАА ХЭЗЭЭД ХҮЧТЭЙ БАЙДАГ

С. Сувдаа